

Санхүүгийн хяналт шалгалт
хийсэн дүнгийн тухай

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын албаны 2022 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын баталсан 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 1/14 дугаар удирдамжийн дагуу Сайхан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2020, 2021 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ж.Оюун 2022 оны 06 сарын 20-ны өдрөөс хуанлын 6 хоногт багтаан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Сайхан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2020, 2021 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, олговор, албан томилолтын бодолт, олголт, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, үлдэгдлийн байдал, нэмэлт орлого түүний бүрдүүлэлт, зарцуулалт, шатахууны олголт, зарцуулалт, хэтрэлт хэмнэлт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг хамруулав.

**ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ
ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

Сайхан сумын тавдугаар багт байршилтай 9013199 регистрийн дугаартай 100 хүүхдийн хүчин чадалтай “Бадрал” цэцэрлэг нь эрхлэгч, арга зүйч 1, дуу хөгжмийн багш 1, үндсэн багш 4, туслах багш 4, ахлах тогооч 1, туслах тогооч 1, нярав 1, сахиул 1, үйлчлэгч 1, нягтлан бодогч 0.5 нийт 16.5 орон тоотойгоор сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг хүргэсэн байна.

Тус сумын хүүхдийн цэцэрлэгийн 2020, 2021 онуудын 01 сарын 01-ний өдрөөс 12 сарын 31-ний өдөр хүртэлх санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд нэгдүгээр гарын үсгийг Э.Баасанхүү, хоёрдугаар гарын үсгийг Д.Цэнд-Аюуш нар зурсан ба сумын төрийн санд бүртгэлийн 100040815201 дугаар, нэмэлт санхүүжилтийн 100040815403 дугаар данстайгаар хөрөнгө мөнгийг захиран зарцуулж ирсэн ба нягтлан бодох бүртгэл болон няравын тайланг “СТS” программаар бүртгэн хөтөлжээ.

2020 онд 01 сарын 02-оос 01 сарын 24-ныг хүртэл 17 өдөр ажиллаж 1011 хүүхэд өдөр, 9 сарын 01-ээс 09 сарын 30-ныг хүртэл 22 өдөр 1409 хүүхэд өдөр, 10 сарын 01-ээс 10 сарын 30-ныг хүртэл 21 өдөр ажиллаж 1906 хүүхэд өдөр, 11 сарын 02-оос 11

сарын 11-ныг хүртэл 8 өдөр ажиллаж 714 хүүхэд өдөр нийт 68 өдөр ажиллаж, нэг өдөрт дунджаар 74 хүүхэд, нэг бүлэгт дунджаар 18 хүүхэд хамруулж, 5040 хүүхэд өдөрт 11,615.1 мянган төгрөгийн хүнсний материал зарцуулсан бол **2021 онд** 03 сарын 01-ээс 03 сарын 26-ныг хүртэл 19 өдөр ажиллаж 1322 хүүхэд өдөр, 9 сарын 23-аас 09 сарын 30-ныг хүртэл 6 өдөр 130 хүүхэд өдөр, 10 сарын 01-ээс 10 сарын 29-нийг хүртэл 21 өдөр ажиллаж 525 хүүхэд өдөр, 11 сарын 01-ээс 11 сарын 30-ныг хүртэл 20 өдөр ажиллаж 563 хүүхэд өдөр, 12 сарын 01-ний өдрөөс 12 сарын 31-ний өдрийг хүртэл 22 өдөр ажиллаж 511 хүүхэд өдөр нийт 88 өдөр ажиллаж, нэг өдөрт дунджаар 35 хүүхэд, нэг бүлэгт дунджаар 11 хүүхэд хамруулж, 3051 хүүхэд өдөрт 7,231.1 мянган төгрөгийн хүнсний материал зарцуулжээ.

Сумын ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч Д.Цэнд-Аюушид цэцэрлэгийн нягтлан бодогчийн албан тушаалыг хавсран гүйцэтгүүлж, үндсэн цалингийн 40 хувиар 2020 оны 02-12 сар, 2021 оны 01-12 сард нийт 7,338.6 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон байна.

Нярав, эд хариуцагчаар 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс 2021 оны 10 сарын 01-ний өдрийг хүртэл Г.Номинхангай, 2021 оны 10 сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал Б.Ариунжаргал ажиллажээ.

ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Сайхан сумын цэцэрлэгийн 2020, 2021 оны санхүүгийн тайлан аудитын түүвэр судалгаанд хамрагдсан байна.

Булган аймгийн Төрийн аудитын газраас Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төсөвт батлагдаагүй байхад ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогчид цэцэрлэгийн нягтлан бодогчийн ажил хавсран гүйцэтгэсэн нэмэгдэл цалин 2,552.6 мянган төгрөг олгосныг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, албан хаагчдад олгохоор тооцсон 28,890.6 мянган төгрөгийн цалинг цалингийн өглөг дансаар дамжуулаагүй шууд зардлаар бүртгэсэн зөрчилд таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн байна. Актаар тогтоосон төлбөрөөс 1,800.0 мянган төгрөгийг 2021 оны 12 сарын 28-нд, 752.0 мянган төгрөгийг 2022 оны 02 сарын 08-нд тус тус аймгийн Төрийн аудитын газрын орон нутгийн орлогын 100040051005 дугаар дансанд төвлөрүүлэн бүрэн барагдуулж, цалингийн зардлаар дамжуулаагүй шууд зардлаар бүртгэсэн зөрчлийг арилгаж, хариуг 2021 оны 05 сарын 28-ны 01/14 тоот албан бичгээр аймгийн Төрийн аудитын газарт өгчээ.

Мөн аймгийн Төрийн аудитын газраас 2021 оны 09 сард тус сумын төсвийн шууд захирагчийн 2020 оны санхүүгийн тайлангийн дараах үе шатны хяналтын ажил, 2021 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар тус сумын хүүхдийн цэцэрлэгийн агуулахын хүнсний материалын үлдэгдэлд тооллого хийж, 7 нэр төрлийн 1,098,766 төгрөгийн хүнс дутагдуулсанд төлбөрийн акт тогтоосон ба үүнээс сумын Эрүүл мэндийн төв 41,480 төгрөгийг цэцэрлэгийн үндсэн дансанд тушаасан байна. Төлбөрийн үлдэгдэл 1,057,286 төгрөгийг 2021 оны 09 сарын 30-нд аймгийн Төрийн аудитын газрын 100040051005 дугаар дансанд шилжүүлжээ.

ЗУРГАА. ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Сайхан сумын цэцэрлэг нь шилэн дансны цахим хуудсанд 2021 онд мэдээлбэл зохих 155 мэдээллийг тогтоосон хугацаанд нь мэдээлж, байршуулсан байна. 2022 оны 1-5-р сард мэдээлбэл зохих 59 мэдээллээс 56 мэдээллийг тогтоосон хугацаанд нь мэдээлж, 3 мэдээллийг хугацаа хоцроож, өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой 8 шийдвэр байршуулсанаас 3 шийдвэрийг PDF форматаар байршуулаагүй байна.

ДОЛОО. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Сайхан сумын цэцэрлэгийн 2020, 2021 оны касс, харилцах, няравын бараа материалын баримт, төсвийн шууд захирагчийн гаргасан А, Б шийдвэр, 4 бүлгийн ирцийн бүртгэл, цагийн бүртгэл, эд хөрөнгийн тооллогын бүртгэл, хүнсний агуулахын бүртгэл, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, санхүүгийн тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилд тогтоосон акт, албан шаардлага, хөдөлмөрийн дотоод журам, дотоод хяналтын тайлан зэрэг холбогдох бусад баримт материалуудад тулгуурлан эрхлэгч Э.Баасанхүү, нягтлан бодогч Д.Цэнд-Аюуш, багш Д.Нарантуяа, нярав Б.Ариунжаргал нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

7.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар:

2020 онд тусгай зориулалтын шилжүүлгээс 295,306.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 22,671.6 мянган төгрөг нийт 317,977.9 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, тодотголоор төсөвт өөрчлөлт оруулан 296,541.8 мянган төгрөгөөр баталсан.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 273,870.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 20,954.6 мянган төгрөг нийт 294,824.8 мянган төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдэж, үйл ажиллагааны зардалд 246,764.9 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 48,059.9 мянган төгрөгийг улсын болон орон нутгийн төсөв /1,065,843 төгрөг/-т буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлт:

/мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт +, Хэтрэлт-
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	191,644.5	170,844.5	157,480.2	+13,364.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,872.0	21,822.0	19,949.6	+1,872.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,671.6	21,471.6	18,689.1	+2,782.5
2104	Хангамж, бараа материалын зардал	13,856.7	18,856.7	21,810.4	-2,953.7
2105	Нормативт зардал	60,321.1	46,385.0	12,464.0	+33,921.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0	1,200.0	1,199.7	+0.3
2107	Томилолт, зочны зардал	397.7	397.7	396.1	+1.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	652.6	2,202.6	1,895.0	+307.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,061.7	12,861.7	12,780.7	+81.0
2132	Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	500.0	500.0	100.0	+400.0
	Дүн	317,977.9	296,541.8	246,764.8	+49,777.0

Дэлхий нийтэд Ковид 19 цар тахал гарч хөл хорио тогтоосноор сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагаа түр зогссонтой холбоотойгоор илүү цагийн хөлс олгогдоогүй, хоолны зардал болон бусад төсөвт зардал хэмнэгдэхэд нөлөөлжээ.

2021 онд тусгай зориулалтын шилжүүлгээс 311,968.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 28,407.5 мянган төгрөг нийт 340,375.5 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, тодотголоор төсөвт өөрчлөлт оруулан 252,473.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 225,441.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 26,565.5 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого (хүнсний буцаалт) 704.9 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 200.0 мянган төгрөг нийт 252,911.5 мянган төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдэж, үйл ажиллагааны зардалд 228,806.1 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 24,105.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлт:

Эдийн засгийн ангилал	Зардлын нэр	/мянган төгрөг/			
		Батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт +, Хэтрэлт-
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	220,749.3	178,478.3	160,602.9	+17,875.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,801.2	24,154.7	20,906.2	+3,248.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,207.5	25,365.5	25,365.5	
2104	Хангамж, бараа материалын зардал	4,353.9	7,253.9	7,447.0	-193.1
2105	Нормативт зардал	52,663.4	12,504.0	10,234.6	+2,269.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200.0	1,200.0	1,200.0	
2107	Томиллолт, зочны зардал	93.7	93.7	93.7	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,778.0	428.0	428.0	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,028.5	2,028.5	2,028.2	+0.3
2132	Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	500.0	500.0	500.0	
	Дүн	340,375.5	252,006.6	228,806.1	+23,200.5

Нэмэлт төсөв: 2020 онд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй.

2021 онд аймгийн БСУГазраас ариутгал халдваргүйжүүлэлтийн 200.0 мянган төгрөгийн орлого орсоноос “Шинэ тун” эмийн сангаас сүүний хүчлийн бактери 60 ширхэг, бээлий 150 ширхэг, санитол 1 ширхэгийг авч, ангиудад тавьж олгосон байна.

7.2 Өглөг, авлагын талаар:

2020, 2021 онд өглөггүй. Авлагын хувьд Улаанбаатар хотын Битачи ХХК-иас авах хүүхдийн сургалтын тоглоомын 6,000.0 мянган төгрөгийн авлагаас 1,660.0 мянган төгрөгийг барагдуулж оны эцэст 4,340.0 мянган төгрөгийн авлагатай байна.

7.3. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:/2020 он/

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж, орон сууц	454,355,240.20	1,912,000.00	4,836,000.00	451,431,240.20
2	Машин тоног төхөөрөмж	37,786,705.08	16,163,140.00	20,005,856.08	33,943,989.00
3	Тавилга, эд хогшил	59,534,299.87	11,518,367.12	4,922,161.87	66,130,505.12
4	Номын фонд	3,204,590.00	0.00	764,070.00	2,440,520.00
5	Программ хангамж	653,500.00	1,350,000.00	653,500.00	1,350,000.00
6	Бусад биет бус хөрөнгө	4,589,120.00	0.00	0.00	4,589,120.00
	Дүн	560,123,455.15	30,943,507.12	31,181,587.95	559,885,374.32

Төсвийн хөрөнгөөр Си Ти Эс ХХК-аас нягтлан бодох бүртгэлийн программ 1,350.0 мянган төгрөгөөр суулгуулсан, Тусгалын өндөр ХХК-иас 1,360.0 мянган төгрөгөөр 4 ширхэг тоглоомын тавиур, 8,600.0 мянган төгрөгөөр хүүхдийн шкаф, Хай теч солушн ХХК-иас 1,940.0 мянган төгрөгийн үнэтэй сүлжээний иж бүрэн камер суурилуулсан, Зөөлөн нунтаг ХХК-иас 2,955.0 мянган төгрөгөөр 13 ширхэг паар, Орхон аймгийн иргэн Жаргалсайханаас 605.0 мянган төгрөгөөр 6 ширхэг оффис хөшиг, Н.Цолмонгоос 920.0 мянган төгрөгөөр 2 ширхэг гурван үйлдэлт принтер, Аргуунномт ХХК-иас 97.0 мянган төгрөгөөр 1 ширхэг принтер нийт 17,827.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан.

БШУЯамны хөрөнгө оруулалтаар 1,749.5 мянган төгрөгийн нэг бүрийн үнэтэй 2 ширхэг Dell маркийн зөөврийн компьютер шилжүүлэн авсан.

Булган аймгийн Орон нутгийн өмчийн газрын албан бичгийн дагуу элэгдлээрээ өртгөө нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан боловч цаашид ашиглалтын шаардлага хангах 45 нэр төрлийн 26,857.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг зах зээлийн үнэд ойртуулан дахин 9,617.5 мянган төгрөгөөр үнэлж үнэлгээг тогтоосон байна.

Сайхан сумын Цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны 01 сарын 14-ний өдрийн А/02 дугаар тушаалаар цаашид ашиглах боломжгүй болсон барилга байгууламж данснаас 1 нэр төрлийн 56.0 мянган төгрөг, номын фонд данснаас 69 нэр төрлийн 764.1 мянган төгрөгийн, машин тоног төхөөрөмж данснаас 9 нэр төрлийн 2,490.8 мянган төгрөг, тавилга эд хогшил данснаас 6 нэр төрлийн 359.9 мянган төгрөгийн нийт 3,670.8 мянган төгрөгийг акталж, данс бүртгэлээс хассан байна.

Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:/2021 он/

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж, орон сууц	451,431,240.20	0.00	0.00	451,431,240.20
2	Машин тоног төхөөрөмж	33,943,98.00	1,869,900.00	2,491,379.00	33,322,510.00

3	Тавилга, эд хогшил	66,130,505.12	0.00	7,961,293.62	58,169,211.50
4	Номын фонд	2,440,520.00	0.00	0.00	2,440,520.00
5	Программ хангамж	1,350,000.00	0.00	0.00	1,350,000.00
6	Бусад биет бус хөрөнгө	4,589,120.00	0.00	0.00	4,589,120.00
	Дүн	559,885,374.32	1,869,900.00	10,452,672.62	551,302,601.70

Төсвийн хөрөнгөөр БСБ электроникс ХХК-иас 1,099.9 мянган төгрөгөөр угаалгын машин, Зөөлөн нунтаг ХХК-иас 210.0 мянган төгрөгөөр цэвэр усны насос төсвийн хөрөнгөөр худалдан авч, БШУЯамны хөрөнгө оруулалтаар 560.0 мянган төгрөгийн үнэтэй 1 ширхэг дээжийн хөргөгч үнэ төлбөргүйгээр өгсөн.

Сайхан сумын Цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны 12 сарын 27-ны өдрийн А/08 дугаар тушаалаар элэгдлээ бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болсон 12 нэр төрлийн 2,491.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 12 нэр төрлийн 7,961.3 мянган төгрөгийн тавилга эд хогшил нийт 24 нэр төрлийн 10,452.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан байна.

7.4. Бараа материалын хөдлөл өөрчлөлт: /2020 он/

№	Тайлангийн нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Бичиг хэрэг	464,440.00	7,988,700.00	7,847,350.00	605,790.00
2	Аж ахуйн материал	41,447,843.62	5,972,524.00	3,404,172.71	44,016,194.91
3	Түлш, шатах тослох	0.00	2,212,000.00	2,212,000.00	0.00
4	Хоол, хүнс	5,535,548.55	8,956,870.00	12,503,354.90	1,989,063.65
	Дүн	47,447,832.17	25,130,094.00	25,966,877.61	46,611,048.56

Сумын цэцэрлэгийн эрхлэгчийн 2020 оны 12 сарын 29-ний өдрийн А/17 дугаар тушаалаар цаашид байгууллагын үйл ажиллагаанд ашиглах боломжгүй болсон 80 нэр төрлийн 298 ширхэг 3,404.2 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө /аж ахуйн материал/-ийг актлан, данс бүртгэлээс хассан байна.

Коронавирус /ковид-19/ халдварт цар тахал өвчин гарч улсын хэмжээнд хөл хорионы дэглэм тогтоосонтой холбогдуулан БШУСайдын 2020 оны 11 сарын 27-ны өдрийн А/162 дугаар тушаалыг үндэслэн хүүхдийн хоолонд зарцуулахаар нөөцөлсөн 2,877.3 мянган төгрөгийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээс 9 нэр төрлийн 888.2 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг хүнсний талонд хамрагддаггүй тус цэцэрлэгт хамрагддаг зорилтот бүлгийн 19 өрхийн 19 хүүхдэд үнэ төлбөргүйгээр олгож, дэмжлэг үзүүлжээ.

Бараа материалын хөдлөл өөрчлөлт: /2021 он/

№	Тайлангийн нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Бичиг хэрэг	605,790.00	4,252,050.00	4,702,590.00	155,250.00
2	Аж ахуйн материал	44,016,194.91	2,833,600.00	17,392,609.88	29,457,185.03
3	Түлш, шатах тослох	0.00	1,846,400.00	1,846,400.00	0.00
4	Хоол, хүнс	1,989,063.65	9,876,393.00	8,993,285.00	2,872,171.65
5	Эм, боох материал	0.00	45,000.00	45,000.00	0.00
6	Барилгын засвар	0.00	1,220,000.00	1,220,000.00	0.00
7	Бусад хангамж	0.00	1,166,000.00	1,166,000.00	0.00

	Дүн	46,611,048.56	21,239,443.00	35,365,884.88	32,484,606.68
--	------------	----------------------	----------------------	----------------------	----------------------

Тус сумын цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны 12 сарын 28-ны өдрийн А/09 дугаар тушаалаар 2021 оны 09 сард аймгийн Төрийн аудитын газраас хийсэн явцын аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу аж ахуйн материалын дансанд бүртгэлтэй 44,016.2 мянган төгрөгийн бараа материалаас 289 нэр төрлийн 1329 ширхэг 17,392.6 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө /аж ахуйн материал/-ийг актлан, данс бүртгэлээс хассан байна.

БШУЯамнаас 123.8 мянган төгрөгийн үнэтэй тусгаарлах өрөөний багц /бинт, хөвөн, хормогч, маск, / 1 ширхэг, 30.0 мянган төгрөгийн үнэтэй автомаск 1 ширхэг, 10.9 мянган төгрөгийн үнэтэй ариутгалын бодис 4 ширхэг нийт 197.4 мянган төгрөгийн материал үнэ төлбөргүйгээр өгсөн.

2021 оны 03 сард үлдсэн нийт 2,242.3 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнээс хонины мах, давс, будаа, чацаргана, элсэн чихэр, гурил зэрэг 7 нэр төрлийн 704.8 мянган төгрөгийн хүнсийг сумын Эрүүл мэндийн төвд худалдсан ба тус байгууллага 2021 оны 05 сарын 25, 07 сарын 30-ны өдөр цэцэрлэгийн үндсэн дансанд хүнсний үнийг бүрэн шилжүүлсэн байна.

Аймгийн Төрийн аудитын газраас 2021 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар цэцэрлэгийн агуулахын хүнсний материалын үлдэгдэлд тооллого хийж, 7 нэр төрлийн 1,098,766 төгрөгийн хүнс дутагдуулсанд төлбөрийн акт тогтоосон ба үүнээс 1,057,286 төгрөгийг 2021 оны 09 сарын 30-нд аймгийн Төрийн аудитын газрын 100040051005 дугаар дансанд шилжүүлжээ.

Нярав Г.Номинхангайгаас Б.Ариунжаргалд няравын ажлыг хүлээлгэн өгөхөд 13 нэр төрлийн 131.5 мянган төгрөгийн хүнс илүү тоологдсоныг хүнсний тайланд орлогодсон байна.

ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

1. Байгууллагад хөтлөгдөж буй шаардах хуудас, хоолны өдөрлөг дугааргүй, засвартай, бараа материалд агуулахын бүртгэл хөтлөөгүй, хүнсний агуулахын бүртгэлд зарлагдсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хаана хэнд олгосон утга, баримтын дугаарыг тавилгүй маягыг дутуу хөтөлсөн, цагийн бүртгэлд цаг бүртгэгчийн гарын үсэг зурагдаагүй, үндсэн хөрөнгө болон бараа материалын үлдэгдлийг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй.

2. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахдаа удирдамжгүйгээр гүйцэтгэсэн, хийсэн хяналт шалгалтын дүнг тухай бүр баримтжуулдаггүй.

3. Удирдлагын гаргасан шийдвэр бичиг хэргийн стандарт хангаагүй, ур чадварын нэмэгдэл олгох тушаалд хүчингүй болсон эрх зүйн акт /БСШУСайд, НХХСайд, Сангийн сайдын 2010 оны 362/112/183 дугаар хамтарсан “Шалгуур үзүүлэлт батлах тухай” тушаал/ үндэслэсэн.

4. Эд хөрөнгийн тооллогыг шаардлага хангахгүй хийсэн байна. Үүнд:Тооллогын комисс эд хөрөнгийн тооллогын бүртгэл, ажилтан албан хаагчдын эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл хөтөлдөггүй, тооллогын бүртгэлийг санхүүгийн программаас хэвлэж гарган гарын үсэг зурж санхүүгийн баримтад хавсаргасан.

5. Шилэн дансны цахим хуудсанд 2022 оны 1-5-р мэдээлбэл зохих мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, өмч хөрөнгө захиран зарцуулах 3 шийдвэрийг PDF форматаар байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-д /тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх/, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр

тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.2.11-д /Төсвийн байгууллага зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор ... нийтэд мэдээлнэ./ заасан заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй.

АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар улсын ахлах байцаагчийн 2 актаар 149.8 мянган төгрөгийн төлбөр тогтоож, зөрчил дутагдлыг арилгуулахаар 1 албан шаардлага үйлдэж, байгууллагын удирдлага болон санхүү, бүртгэлийн 3 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

ДҮГНЭЛТ

Тус сумын цэцэрлэгийн санхүү, аж ахуйн үйл ажиллагааны баримтууд эмх цэгцтэй, анхан шатны баримтын бүрдэлт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт хангалттай байгаа ч дотоод хяналт шалгалтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулиуд болон холбогдох тушаал, дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллах

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоод хяналт шалгалтыг тогтмол хийж, гүйцэтгэлийг хянан баримтжуулж, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр ирүүлэх

Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, төлбөрийн актыг тогтоосон хугацаанд бүрэн барагдуулах

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Ж.ОЮУН

